



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 04 өдөр

Дугаар A/06

Ховд

Г Олон улсын хуралд оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "а" заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд хот АНУ-ын California мужийн Borrego Springs хоттой эгч дүүсийн харьцаа тогтоон цаашид нийгэм, эдийн засаг, үйлдвэр, байгаль орчин, боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр хамтран ажиллах саналыг Монгол улсаас АНУ-ын Сан Франциско хотод суугаа ерөнхий консулын газарт санал тавьж хамтран ажилласан. Иймд 2019 оны 2 сарын 9-өөс 14-ний өдрүүдэд АНУ-ын Калифорни мужийн Боррего спринг хотод албан ёсны айлчлалд аймгийн Засаг дарга Б.Дүгэржав, Ховд аймгийн Жаргалант сумын Засаг дарга Ц.Ганданповрон, Төрийн аудитын газрын дарга Х.Болдбаатар, ахлах мэргэжилтэн Л.Галбадрах, аймгийн ИТХ-дахь МАН-ын бүлгийн дарга, аймгийн ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч М.Ганзориг, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Э.Дөлбадрал, Гадаад харилцааны мэргэжилтэн Б.Эрдэнэчимэг, Ховд их сургуулийн гадаад хэлний тэнхимиин эрхлэгч, доктор, орчуулагч В.Сайнбаяр нарыг томилон оролцуулсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/06 Ch

02 00065